



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 1178

Шивээговь сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5².1, 8 дугаар зүйлийн 8.1.1, 9 дүгээр зүйлийн 9.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Улсын хэмжээнд урлаг, соёл спортын үйл ажиллагааг заал, танхимын 50 хувийн дүүргэлттэйгээр зохион байгуулах шийдвэр гарсантай холбогдуулан зохион байгуулагдаж байгаа арга хэмжээнд оролцож байгаа иргэдийн түргэвчилсэн шинжилгээ, дархлаажуулалтын бүрэн тун болон дархлаа сэргээх нэмэлт 3 дугаар тунд хамрагдсан эсэх, заал танхимын дүүргэлт, ариутгал халдваргүйжүүлэлтэд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

Ч.Сугармаа (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга:

Ш.Буяаннэмэх (Мал эмнэлгийн улсын байцаагч)

Гишүүд:

Б.Мөнхцэцэг (Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Д.Отгонбаатар (Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

П.Дэлгэрбаяр (Цагдаагийн хэсгийн Хэсгийн төлөөлөгч)

Д.Буяндэлгэр (Ерөнхий


боловсролын сургуулийн захирал)

Б.Даваадолгор (3 дугаар
цэцэрлэгийн эрхлэгч)

Х.Сувданцэцэг (Эрүүл мэндийн
төвийн даргын үүргийг түр орлон
гүйцэтгэгч)

2. Хяналт шалгалтыг шуурхай, үр дүнтэй зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ